



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/32/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Я.Самбууням

Утас: 260949

Цахим хаяг: Sambuunyamya@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 261885

Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Р.Цолмон

Утас: 261628

Цахим хаяг: Tsolmonr@audit.gov.mn

Аудитор: П.Амарсанаа

Утас: 261628

Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаатар

Утас: 261628

Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа	12
3.5.4 Бараа материал.....	12
3.5.5 Үндсэн хөрөнгө	13
3.5.6 Өр төлбөр	13
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5.8 Зардлын данс	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Шилэн дансны мэдээлэл	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
Албан шаардлага	17
Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЭНХБОЛД ТАНАА

2021.04.26 № 1315
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолд заасны дагуу сангийн 8 хувь буюу 40,523.0 сая төгрөгөөр эрсдэлийн сангийн нөөц байгуулахаас тайлант онд 20,523.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан;
- ЭМДС-гийн 54,518.8 сая төгрөгийг төлбөр гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршуулсан нь мөнгөн хөрөнгө эргэж төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн зэрэг нийт 75,041.8 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, Төсвийн тухай хууль, Банкны тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоол, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

\\10.10.10\Bichia\Khurel\Yawsan\Bichia\2021\0426\auditin 2-R\gazar17.Docx

001030317

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	738,442,786.1	797,535,768.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	557,520,331.5	617,256,246.1
33	АВЛАГА	180,157,142.1	177,018,544.9
34	УРЬДЧИЛГАА	706,012.9	3,148,275.8
35	БАРАА МАТЕРИАЛ	59,299.6	112,701.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,674,626.2	4,000,883.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,674,626.2	4,000,883.4
39200	Биет хөрөнгө	2,718,396.4	3,118,680.2
39300	Биет бус хөрөнгө	942,435.9	882,203.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	742,117,412.3	801,536,651.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,671,948.8	2,639,135.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,671,948.8	2,639,135.5
41300	Өглөг	2,665,389.8	2,638,974.1
41400	Урьдчилж орсон орлого	6,558.9	161.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	739,445,463.5	798,897,516.2
51	Засгийн газрын хувь оролцоо	739,445,463.5	798,897,516.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,793.9	13,793.9
51200	Хуримтлагдсан үр дүн	739,431,669.6	798,883,722.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	742,117,412.3	801,536,651.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	510,212,740.5	481,381,924.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	494,850,381.5	421,524,437.7
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	494,850,381.5	421,524,437.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,029.6	51,054,096.3
120	Нийтлэг татварын бус орлого	206,029.6	51,054,096.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,156,329.4	8,803,390.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	363,795,578.4	421,929,871.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	363,795,578.4	421,929,871.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,831,814.6	4,275,607.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,288,072.7	2,558,943.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	287,574.6	323,950.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,357.6	54,010.2
2104	Хангамж, бараа материалын зардал	188,276.7	193,653.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,127.1	169,299.8
2107	Томилолт, зочны зардал	178,412.5	79,758.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,391.1	171,207.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	560,602.2	724,784.4
212	ТАТААС	40,613,561.8	41,088,538.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,350,201.9	376,565,725.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	146,417,162.1	59,452,052.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	146,417,162.1	59,452,052.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	592,266,373.6	-	592,266,373.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	761,927.7	-	761,927.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	593,028,301.4	-	593,028,301.4
9	Тайлант үеийн үр дүн	146,417,162.1	-	146,417,162.1
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	739,445,463.5	-	739,445,463.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	739,445,463.5	-	739,445,463.5
19	Тайлант үеийн үр дүн	59,452,052.7	-	59,452,052.7
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	798,897,516.2	-	798,897,516.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	484,892,591.3	494,262,124.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	469,617,770.1	485,431,035.5
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	469,617,770.1	485,431,035.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,367.3	4,837.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,367.3	4,837.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,273,453.8	8,826,251.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,341,181.8	433,863,352.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,341,181.8	433,863,352.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,738,249.4	13,588,688.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,856,312.0	2,181,963.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,587.3	297,735.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,357.6	54,010.2
2104	Хангамж, бараа материалын зардал	180,931.2	222,043.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	264,703.0	194,588.3
2107	Томилолт, зочны зардал	176,433.7	84,902.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	809,893.5	10,330,673.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,031.0	222,771.0
212	ТАТААС	40,549,224.5	41,108,635.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,053,707.9	379,166,028.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	119,551,409.4	60,398,771.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	137,005,541.6	662,856.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,005,541.6	662,856.9
2200	Дотоод эх үүсвэрээр	137,005,541.6	662,856.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-662,856.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-17,454,132.2	59,735,914.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	574,974,463.7	557,520,331.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	557,520,331.5	617,256,246.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	494,538,344,100.00	426,384,365,453.73	68,153,978,646.27	86.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,538,344,100.00	426,384,365,453.73	68,153,978,646.27	86.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,233,771,100.00	14,251,545,762.12	10,982,225,337.88	56.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,261,102,400.00	2,181,963,734.37	79,138,665.63	96.5
210101	Үндсэн цалин	1,305,766,300.00	1,265,219,437.69	40,546,862.31	96.9
210102	Нэмэгдэл	523,067,600.00	501,178,985.83	21,888,614.17	95.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	155,960,000.00	145,817,000.00	10,143,000.00	93.5
210104	Урамшуулал	276,308,500.00	269,748,310.85	6,560,189.15	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	336,249,000.00	297,735,536.21	38,513,463.79	88.5
210201	Тэтгэврийн даатгал	227,804,800.00	206,388,048.45	21,416,751.55	90.6
210202	Тэтгэмжийн даатгал	26,771,100.00	22,847,157.76	3,923,942.24	85.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,688,800.00	18,380,774.61	3,308,025.39	84.7
210204	Ажилгүйдлийн даатгал	9,162,200.00	4,547,780.18	4,614,419.82	49.6
210205	Эрүүл мэндийн даатгал	50,822,100.00	45,571,775.21	5,250,324.79	89.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,000,000.00	54,010,178.33	127,989,821.67	29.7
210301	Гэрэл, цахилгаан	35,000,000.00	23,082,920.00	11,917,080.00	66.0
210302	Түлш, халаалт	40,000,000.00	22,407,335.03	17,592,664.97	56.0
210303	Цэвэр, бохир ус	32,000,000.00	3,619,923.30	28,380,076.70	11.3
210304	Байрны түрээс	75,000,000.00	4,900,000.00	70,100,000.00	6.5
2104	Хангамж, бараа материалын зардал	234,160,600.00	225,471,703.00	8,688,897.00	96.3
210401	Бичиг хэрэг	66,572,100.00	65,232,400.00	1,339,700.00	98.0
210402	Тээвэр, шатахуун	45,813,400.00	40,693,300.00	5,120,100.00	88.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,000,000.00	52,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,775,100.00	67,546,003.00	2,229,097.00	96.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	812,000,000.00	746,144,368.00	65,855,632.00	91.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	612,000,000.00	568,137,888.00	43,862,112.00	92.8
210604	Урсгал засвар	200,000,000.00	178,006,480.00	21,993,520.00	89.0
2107	Томилолт, зочны зардал	125,534,400.00	84,902,511.00	40,631,889.00	67.6
210702	Дотоод албан томилолт	125,534,400.00	84,902,511.00	40,631,889.00	67.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,027,298,800.00	10,438,366,686.21	10,588,932,113.79	49.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,857,837,600.00	10,301,114,924.21	10,556,722,675.79	49.4
210803	Даатгалын үйлчилгээ	10,000,000.00	6,019,240.00	3,980,760.00	60.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	281,094.00	718,906.00	28.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,000,000.00	915,950.00	2,084,050.00	30.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	138,686,000.00	129,264,998.00	9,421,002.00	93.2
210807	Газрын төлбөр	3,476,400.00	159,440.00	3,316,960.00	4.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,298,800.00	611,040.00	687,760.00	47.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,425,900.00	222,951,045.00	32,474,855.00	87.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	179,020,900.00	179,020,900.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,405,000.00	43,930,145.00	32,474,855.00	57.5
212	ТАТААС	50,335,799,000.00	41,108,635,128.00	9,227,163,872.00	81.7
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50,335,799,000.00	41,108,635,128.00	9,227,163,872.00	81.7
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50,335,799,000.00	41,108,635,128.00	9,227,163,872.00	81.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	418,968,774,000.00	371,024,184,563.61	47,944,589,436.39	88.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	418,524,126,500.00	370,715,323,184.45	47,808,803,315.55	88.6
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	418,524,126,500.00	370,715,323,184.45	47,808,803,315.55	88.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	444,647,500.00	308,861,379.16	135,786,120.84	69.5
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	240,000,000.00	201,562,683.16	38,437,316.84	84.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	149,647,500.00	63,566,700.00	86,080,800.00	42.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,000,000.00	43,731,996.00	11,268,004.00	79.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	494,538,344,100.00	476,520,280,023.35	18,018,064,076.65	96.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	494,538,344,100.00	476,515,442,860.35	18,022,901,239.65	96.4
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	494,538,344,100.00	476,515,442,860.35	18,022,901,239.65	96.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	4,837,163.00	4,837,163.00	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,837,163.00	4,837,163.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	557,520,331,504.38	557,520,331,504.38	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	607,656,246,073.96	607,656,246,073.96	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	
610001	Төсвийн байгууллага	3	3	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	177	173	4	97.7
620001	Удирдах ажилтан	5	5	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	172	168	4	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	177	173	4	97.7
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	102	102	-	
650002	Ажлын алба (АА)	18	16	2	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	57	55	2	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,826,251,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,826,251,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,826,251,500.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,803,390,500.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,803,390,500.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,861,000.0
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	22,861,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,826,251,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,826,251,500.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,803,390,500.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,861,000.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хуульд заасан бүрэлдэхүүний дагуу тайлагнах, харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчлүүдийг арилгахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, Аудитын дөрөвдүгээр газрын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/452 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн даатгалын сангийн эрхэм зорилгыг “Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, чөлөөт үлдэгдлийг банканд байршуулах, даатгуулагчийн тусламж үйлчилгээ түүний төлбөр хяналт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгооны талаар өөрчлөлт орсон байна.

Мөн тайлант онд байгууллагын үйл ажиллагааг засаглах удирдлага болон санхүү, бүртгэлийн хэлтсийн даргыг шинээр томилсон байна. Тодруулбал:

- ЭМДЕГ-ын дарга Л.Бямбасүрэн нь Засгийн газрын 2020 оны 111 дүгээр тогтоолоор томилогдсон байна.
- Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нь ЭМДЕГ-ын даргын 2020 оны Б/176 дугаар тушаалаар томилогдсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн бүтцэд дотоод аудитын нэгж, хэлтэсгүй бөгөөд дотоод аудитор томилогдоогүй тул тайлант онд төлөвлөгөөт хяналт, шалгалт хэрэгжүүлээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 422,614.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4,226.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 557,520.3 сая, эцсийн үлдэгдэл 617,256.2 сая төгрөг болж, 59,735.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	324,520.3	267,256.2	-57,264.1	-95.9
Хадгаламж	233,000.0	350,000.0	117,000.0	195.9
Дүн	557,520.3	617,256.2	59,735.9	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 108,695.2 сая төгрөг төрийн сангийн харилцахад, 158,561.0 сая төгрөг арилжааны банкны харилцахад тус тус байршиж байна. Мөн мөнгөн хөрөнгө 59,735.9 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын зарцуулаагүй үлдэгдэл болон хадгаламжийн хүүгийн орлогыг ЭМДС-д төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хадгаламж хэлбэрээр Капитрон банканд 10,000.0 сая төгрөг, Хас банканд 20,000.0 сая төгрөг, Голомт банканд 40,000.0 сая төгрөг, Төрийн банканд 45,000.0 сая төгрөг, Худалдаа, хөгжлийн банканд 120,000.0 сая төгрөг, Хаан банканд 115,000.0 сая төгрөг тус тус байршиж байна.

ЭМДҮЗ-ийн 2020 оны “Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулах тухай” 03 дугаар тогтоолоор дээрх эх үүсвэрийг банканд байршуулж Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6-д “сангийн чөлөөт үлдэгдлийн хүү”-гийн орлогыг санд төвлөрүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд 54,518.8 сая төгрөг байршиж байгаа бөгөөд мөнгөн хөрөнгө эргэж төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 180,157.1 сая, эцсийн үлдэгдэл 177,018.6 сая төгрөг болж, 3,138.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1.0	1.0
Татаас, санхүүжилтийн авлага	26,529.8	26,518.2	-11.7
Татвар, НДШ-ын авлага	0.0	137.8	137.9
Байгууллагаас авах авлага	153,627.3	150,361.5	-3,265.8
Дүн	180,157.1	177,018.5	-3,138.6

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд он удаан жил болсон 166,617.5 сая төгрөгийн авлага байна. Тухайлбал:

- 2018 онд НДЕГ-аас шилжиж ирсэн ХНХЯ-аас авах 4,388.2 сая төгрөг, мөн “Эрүүл хүүхэд, эрүүл шүд хөтөлбөр”-ийн хүрээнд бий болсон дүүрэг, аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудаас авах 444.0 сая, Капитал банканд байршуулж байсан чөлөөт эх үүсвэртэй холбоотой тус банкны төлбөр барагдуулах чадваргүй болсноос үүссэн 135,290.0 сая төгрөг;
- 2018, 2019 онд үүссэн ХНХЯ-аас авах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцах иргэдийн 26,495.3 сая төгрөгийн авлага тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх оноос шилжиж ирсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,495.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Тайлант оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 137.8 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 706.0 сая, эцсийн үлдэгдэл 3,148.2 сая төгрөг болж, 2,442.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	706.0	3,148.2	2,442.2
Дүн	706.0	3,148.2	2,442.2

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгт, тусламж үйлчилгээний урьдчилгаа санхүүжилт авсан боловч Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж үйл ажиллагаа хязгаарлагдсан дараах эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл гараагүйтэй холбоотой байна. Тухайлбал: Цэргийн төв эмнэлэг 1,740.4 сая, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг 722.1 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төв 119.9 сая, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг 59.7 сая төгрөг тус тус байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 59.3 сая, эцсийн үлдэгдэл 112.7 сая төгрөг болж, 53.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	7.1	21.1	14
Аж ахуйн материал	7.3	25.7	18.4
Сэлбэг хэрэгсэл	9.5	12.4	2.9
Түлш, шатах тослох материал	3.8	4.8	1.0
Бусад хангамжийн материал	31.6	48.7	17.1
Дүн	59.3	112.7	53.4

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар тайлант оны эцэст Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 53.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нөөцөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны эцэст төсвийн хэмнэлтээс 13.4 сая төгрөгийн шатахуун худалдан авч нөөц үүсгэсэн байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,674.6 сая, эцсийн үлдэгдэл 4,000.8 сая төгрөг болж, 326.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,848.3	1,798.3	-50.0
Авто тээврийн хэрэгсэл	155.8	129.3	-26.5
Машин тоног төхөөрөмж	468.0	953.0	485.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	227.1	216.2	-10.9
Бусад үндсэн хөрөнгө	19.3	22.0	2.7
Газар	13.7	13.7	-
Бусад биет бус хөрөнгө	-	73.0	73.0
Программ хангамж	942.4	795.3	-147.1
Дүн	3,674.6	4,000.8	326.2

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 662.8 сая, өмнөх онд худалдан авсан 60.2 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 161.1 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж зэргийг нэмж бүртгэснээс өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Эзэмших эрхийн зориулалттай 414.0 м2 газрыг санхүүгийн тайланд "Газар" дансанд 13.7 сая төгрөгөөр бүртгэж, тайлагнасан.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,671.9 сая, эцсийн үлдэгдэл 2,639.1 сая төгрөг болж, 32.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				100

Татаас, санхүүжилтийн өглөг	2,546.6	2,546.6	-	-
Байгууллагад төлөх өглөг	118.8	92.4	-26.4	-80.5
Урьдчилж орсон орлого	6.6	0.1	-6.5	-19.5
Нийт дүн	2,672.0	2,639.1	-32.9	100

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд санхүүжилт олгодог харилцагч байгууллагуудад төлөх төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын 2,546.6 сая төгрөгийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрүүл мэндийн даатгалын сан нь Нийслэлийн нийгмийн даатгалын газарт 1,077.5 сая төгрөг, Дархан-Уул аймагт 757.6 сая төгрөг, Хөвсгөл аймагт 434.7 сая төгрөг, Ховд аймагт 177.3 сая төгрөг, Сэлэнгэ аймагт 90.2 сая төгрөг, Дорноговь аймагт 9.1 сая төгрөг, нийт 2,546.6 сая төгрөгийн төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын өглөг бүртгэлтэй байгаа бөгөөд 2017 оноос тайлант он хүртэл талууд барагдуулах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 739,445.4 сая, эцсийн үлдэгдэл 798,897.5 сая төгрөг болж, 59,452.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13.8	13.8	-	-
Засгийн газрын хувь оролцоо	739,431.6	798,883.7	59,452.1	100
Дүн	739,445.4	798,897.5	59,452.1	100

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдлийн 13.8 сая төгрөг нь эзэмших зориулалттай 414.0 м2 газрын үнэлгээ байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 798,897.5 сая төгрөг болж 59,452.1 сая төгрөгөөр өссөн нь сангийн мөнгөн хөрөнгө өссөнөөс шалтгаалжээ.

3.5.8 Зардлын данс

Зардлын дансадтай холбоотой 219.5 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд 50.8 сая төгрөгөөр бичиг хэргийн материал, 101.0 сая төгрөгөөр аж ахуйн материал, 40.3 сая төгрөгөөр бусад хангамж материалыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн байна.
- Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсдад 8.5 сая төгрөгийн урамшуулал, 14.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл тус тус илүү олгосон байна.
- Байгууллагын дотоод журамд нийцэхгүй гадаад хэлний элсэлтийн шалгалт /TOEFL/-ын сургалтын төлбөр 4.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 527,868.6 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,330.3 сая төгрөгөөр бууруулж 506,538.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд энэ нь хувийн эмнэлэг, эмийн санд олгох татаас, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг бууруулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэх нийт зардлын эх үүсвэрийг 494,538.4 сая төгрөгөөр эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 557,520.3 сая төгрөг, тайлант онд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоос 476,515.4 сая, бусад орлогоос 4.8 сая, нийт 476,520.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 426,384.3 сая төгрөгийг зарцуулж, сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 607,656.2 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 426,384.3 сая төгрөг буюу 86.2 хувьтай байгаа нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас дараах зардлуудыг дутуу зарцуулсан байна. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 79.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 38.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 127.9 сая, хангамж бараа материалын зардал 8.6 сая, эд хогшил, урсгал засварын зардал 65.8 сая, томилолт зочны зардал 40.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр 10,588.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 32.4 сая, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 9,227.1 сая, урсгал шилжүүлэг 47,944.5 сая, нийт 68,153.9 сая төгрөгийн зардлыг дутуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн яамнаас эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, гемодиализ эмчилгээнд 8,803.3 сая, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагаас 22.8 сая, нийт 8,826.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 8,803.3 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 22.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.3-т заасан "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банканд хадгалуулах журам"-д Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 22 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж дээрх журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-т "Хүн амыг олноор хамарч удаан хугацааны эмчилгээ, зардал шаардагдах өвчин, халдварт цах тахлын тархалтыг таслан зогсооход шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эм, эмийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх" гэж заасныг үндэслэн 2020 оны эрсдэлийн сангийн хөрөнгөөс 9,600.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын дансанд тусгаарлан 2021 онд 16 аймаг, 2 дүүрэгт "Хүчил төрөгчийн бэсрэг үйлдвэрийн баллон" барих ажилд зарцуулахаар тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хийгдэж байна.

Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг санхүүжүүлдэг байгууллага төлөвлөөгүй хөрөнгө оруулалтын шинжтэй ажлыг журамд өөрчлөлт оруулан зарцуулж байгаа асуудлыг онцолж байна.

Харин бусад асуудалд Засгийн газрын 2017 оны 344 дугаар “Агентлаг байгуулах тухай” тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар байгуулахад санхүүгийн тайлангийн үлдэгдэлд 132,537.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө шилжиж ирсэн боловч тус банк барагдуулах чадваргүй болсны улмаас шүүхийн шийдвэрээр Капитал банкнаас авах 136,113.2 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Монголбанкнаас томилогдсон тус банкны эрх хүлээн авагч 2020 онд 823.2 сая төгрөгийн авлага барагдуулсан. Цаашид банк өөрийн хөрөнгийг арилжаалж борлуулсны дараа мөнгөөр авлагыг барагдуулах боломжтой эсвэл үл хөдлөх хөрөнгө авах саналыг ирүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

ЭМДС-гийн 54,518.8 сая төгрөгийг төлбөр гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршуулсан нь мөнгөн хөрөнгө эргэж төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сан 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 чиглэлийн 2 ажил нь эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоон өсөлт /өмнөх жилтэй харьцуулсан хувиар/, эрүүл мэндийн даатгалын, тусламж үйлчилгээ авсан хүний тоо /Давхардсан тоогоор сая хүн/ Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд заасан зорилтот түвшинд хүрч биелсэн байна.

Энэ нь эрүүл мэндийн даатгалын хамралт 2019 онд 2,920.9 мянган даатгуулагч, 2020 онд 2,999.7 мянган даатгуулагч давхардсан тоогоор хамрагдсан байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 3 хувийн өсөлттэй байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээг давхардсан тоогоор 2019 онд 8.6 сая даатгуулагч, 2020 онд 9.8 сая даатгуулагчид үзүүлсэн байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 518 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 218 мэдээлэл, хугацаа хоцроож 169 мэдээллийг байршуулсан, огт мэдээлээгүй 125, хугацаа болоогүй 6 мэдээлэл байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 31,801.8 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №8. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1				1	-	0.0
Зөвлөмж	1	31,801.8	1	20,000.0	1	11,801.8	63.0
Нийт	2	31,801.8	1	20,000.0	1	11,801.8	63.0

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2020 оны эрсдэлийн сангийн хөрөнгөөс 9,600.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын дансанд тусгаарлан 2021 онд 16 аймаг, 2 дүүрэгт "Хүчил төрөгчийн бэсрэг үйлдвэрийн баллон" барих ажлыг санхүүжүүлж байна. Тус худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулж ажилласан эсэхийг дараагийн аудитаар анхаарах асуудал гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэснээс 2 тайлан аудитад хамрагдаж Зөрчилгүй 1, Хязгаарлалттай 1, аудитын түүвэрт хамрагдсан 1 тайлан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 7,763.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 175,890.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 26,704.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 149,186.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 75,041.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3 зөрчилд 75,041.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Албан шаардлага

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолын 1-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсугай" гэж заасны дагуу 506,538.3 сая төгрөгийн 8 хувь буюу 40,523.0 сая төгрөгөөр эрсдэлийн сангийн нөөц байгуулахаас тайлант онд 20,523.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.2-т "эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах", мөн хуулийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна", ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолын 1-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. ЭМДС-гийн 54,518.8 сая төгрөгийг төлбөр гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршуулсан нь мөнгөн хөрөнгө эргэж төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн "Эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүрэг"-ийн 16.1.2-т "эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх".гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1. Харьяа байгууллагуудтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 1 санхүүгийн тайлан зөрчилгүй, 1 санхүүгийн тайлан хязгаарлалттай, 1 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитаар нийт 183,654.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7,763.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 26,704.8 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 149,186.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад илэрсэн зөрчлийг давтан гаргуулахгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/											
дд	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Эрүүл мэндийн даатгалын сан		1			-	-	3	75,041.8	1	-
	ДҮН		1					3	73,519.1	1	-
Засгийн газрын тусгай сан											
2	Эрүүл мэндийн даатгалын сан		1					1	26,495.3	2	148,995.6
	ДҮН		1					1	26,495.3	2	148,995.6
Төсвийн шууд захирагч											
3	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	1						1	-	1	-
	ДҮН	1						1		1	
Түүврийн байгууллага											
4	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар							4	209.5	4	190.5
	ДҮН							4	209.5	4	190.5
	НИЙТ ДҮН	1	2					9	101,746.6	8	149,186.1

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Эрүүл мэндийн даатгалын сан ТЕЗ					
1	Эрсдэлийн сангийн хэмжээг нийт орлого 506,538.3 сая төгрөгийн 8 хувь буюу 40,523.0 сая төгрөгөөр эрсдэлийн сангийн нөөц байгуулахаас тайлант онд 20,523.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан	20,523.0	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Г.Баясгалан Б.Болормаа
2	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд 54,518.8 сая төгрөг байршиж байгаа бөгөөд мөнгөн хөрөнгө эргэж төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн	54,518.8	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Г.Баясгалан Б.Болормаа
3	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчдын зүгээс дотоод аудит хийгдээгүй	-	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Л.Бямбасүрэн Л.Нарантуяа
Эрүүл мэндийн даатгалын сан ЗГТС					
5	Өмнөх оноос шилжиж ирсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,495.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	26,495.3	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Г.Баясгалан Б.Болормаа
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар					
6	Тайлант оны эцэст 13.4 сая төгрөгийн шатахуун худалдан авч нөөц үүсгэсэн байна.	13.4	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Л.Бямбасүрэн Л.Нарантуяа
7	Мөн журамд заагаагүй TOEFL /гадаадын их дээд сургуульд элсэх/ англи хэлний шалгалтын төлбөр 4,000,000 /Дөрвөн сая/ төгрөгийг олгосон байгаа	4.0	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, нягтлан бодогч	Г.Баясгалан Б.Батдаваа
8	Тайлант онд 50.8 сая төгрөгөөр бичиг хэргийн материал, 101.0 сая төгрөгөөр аж хуйн материал, 40.3 сая төгрөгөөр бусад хангамж материалыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн	192.1	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, нягтлан бодогч	Г.Баясгалан Б.Батдаваа
9	Шилэн дансны мэдээллийн санд 163 мэдээлэл оруулахаас 3 оруулаагүй, 93 хугацаа хоцроосон, 67 хугацаандаа мэдээлсэн байна.	-	Албан шаардлага	ЭМДС-ийн дарга, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, нягтлан бодогч	Г.Баясгалан Б.Болормаа Б.Батдаваа
Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл					
10	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 53 мэдээллийг хугацаанд нь 24 мэдээллийг хугацаа	-	Албан шаардлага	Ажлын албаны дарга, нягтлан бодогч-аудитор	Л.Номин Д.Сувдаа

	хоцроож байршуулсан, 44 мэдээллийг байршуулаагүй байна.				
	Дүн	101,746.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 588/A0110001

Улаанбаатар хот

САГ-2021/32/СТА-ТЕ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа газруудад илэрсэн зөрчлийг давтан гаргуулахгүй байхад цаашид анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

1/10.10.2020\otag_khorog\alban-shaardlaga\2021\04\mendin-3-4\Gamer44.Docx

001081385



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 586/АД110001

Улаанбаатар хот

САГ-2021/32/СТА-ТЕ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурсан нэр бүхий 2 банкны харилцах дансанд 54,518.8 сая төгрөг байршиж байгаа бөгөөд тус мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т "эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банкны харилцах дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгийг төрийн сан дахь төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, сангийн мөнгөн хөрөнгийг эрсдэлгүй удирдахад анхаарч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дугаар сарын 01-ны дотор үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга С.Энхболд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

1/10.19.10.2018/daig_khreeg/Alban Shaardlaga/2021/04/Montevio 3-A/Green-43 Data

001081382



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 584/А0110001
САГ-2021/32/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг 506,538.3 сая төгрөгийн 8 хувь буюу 40,523.0 сая төгрөгөөр байгуулахаас тайлант онд 20,523.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.2-т "эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах", мөн хуулийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна", ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолын 1-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг байгуулахдаа хууль, журамд заасан хувь хэмжээгээр байгуулах, дээд шатны төсөв захирагчийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга С.Энхболд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Л.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

11.0.10.10.20010001_KhoregAlbanShaardlaga/2021/0428audite 1-R Gonor/2 Docx

001081379